



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 21 өдөр

Дугаар А/825

Ховд

Зарим үйлчилгээний байгууллагуудыг нээж,
цагийн хуваарь тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын “ж”, “л”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.8, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт, аймгийн Онцгой комиссын хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 39 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Бэлэн байдлын зэргийг бууруулах тухай” 209 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа спорт заал, бялдаржуулах танхим, үсчин гоо сайхан, сургалтын төвүүдийн үйл ажиллагааг нээж, 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн 09:00 цагаас 21:00 цагийн хооронд үйл ажиллагаа явуулахаар цагийн хуваарийг тогтоосугай.

2. Тухайн газруудад Эрүүл мэндийн яамнаас өгч байгаа халдвар хамгааллын дэглэмийг мөрдөх, ариутгал халдваргүйжүүлэлтийг тухай бүр хийж ажиллуулахыг байгууллагын удирдлагуудад даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэн сурталчилж ажиллахыг сумдын Засаг дарга нар, Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Э.Даваасүрэн/, Мэргэжлийн хяналтын газар /П.Эрдэнэчулуун/, аж ахуйн нэгжүүдийн удирдлагуудад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Zax A/825 Ch
02 4162